

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/12/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор : Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Ц.Хосжаргал Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn Аудитор: С.Отгонхорлоо Утас: 261740 Цахим хаяг: otgonkhorloos@audit.gov.mn Дундманхайдай аудит ХХК-ийн захирал Ж.Бямбажав Цахим хаяг: info@dumaudit.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭДИЙН ЗАСГИЙН
ХҮРЭЭЛЭН ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
М.ТҮМЭНЖАРГАЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.15 № 07/719
танай _____-ны № _____-т
Г **Өөрчлөлтгүй дүгнэлт** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

ТӨБЗГ-ын 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 231 дүгээр тогтоолоор “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨААТҮГ-ын зохион байгуулалтын бүтцийн схем, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн баталсан байна. Үүнийн дагуу бүтэц, орон тооны өөрчлөлт хийж 2 ажилтан цомхотгосон ба тусгай зөвшөөрлийн эрх олгох чиг үүрэг өөр байгуулагад шилжсэн байна.

Аудитын гол асуудал

Нийт авлагын 39.5 хувь буюу 299.9 сая төгрөгийн авлага нь Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XII.4.5 дугаар заалтын дагуу Эрчим хүчний яамны захиалгаар Барилга, хот байгуулалтын яамнаас зарласан “Таван толгойн түлш ХХК-ийн зүүн бүсийн үйлдвэрийн талбайд шинээр сайжруулсан шахмал түлшний үйлдвэр барих техник эдийн засгийн үндэслэл боловсруулах” зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтад шалгаран 2022/160 дугаартай гэрээг 2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр байгуулсан байна. Дээрх гэрээт ажлыг бүрэн гүйцэтгэн захиалагч талд хүлээлгэн өгсөн боловч хариуцагч тал буюу Барилга хот байгуулалтын яам гэрээний дагуу төлбөрийг барагдуулаагүйгээс үүссэн 2 жилийн насжилттай авлага байна.

0001051473

Бусад асуудлын хэсэг

Хүрээлэн нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 60 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 99.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.Наранчимэг

Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	485,954,483.02	583,257,902.85
1.1.02	Дансны авлага	929,691,185.60	757,741,142.45
1.1.04	Бусад авлага	1,900,000.00	1,000,000.00
1.1.06	Бараа материал	92,338,322.57	83,120,679.06
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,509,883,991.19	1,425,119,724.36
1.2.01	Үндсэн хөрөнгө	882,392,291.45	828,248,427.34
1.2.02	Биет бус хөрөнгө	243,943,260.22	201,508,412.00
1.2.06	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	1,449,838.32
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,126,335,551.67	1,031,206,677.66
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,636,219,542.86	2,456,326,402.02
2.1.1.03	Татварын өр	425,596,885.02	229,423,234.52
2.1.1.07	Ногдол ашгийн өглөг	100,000,000.00	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	525,596,885.02	229,423,234.52
2.1.2.03	Хойшлогдсон татварын өр	5,271,673.68	5,896,365.87
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	5,271,673.68	5,896,365.87
2.2	Өр төлбөрийн нийт дүн	530,868,558.70	235,319,600.39
2.3.01	Өмч: - төрийн	913,718,777.62	913,718,777.62
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	131,198,748.06	133,648,028.56
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	92,192,981.37	92,192,981.37
2.3.09	Хуримтлагдсан ашиг	968,240,477.11	1,081,447,014.08
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	-	113,206,536.97
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	968,240,477.11	968,240,477.11
2.3.11	Эздийн өмчийн дүн	2,105,350,984.16	2,221,006,801.63
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,636,219,542.86	2,456,326,402.02

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,939,349,207.85	1,862,896,069.21
2	Борлуулалтын өртөг	686,575,856.77	172,129,510.74
3	Нийт ашиг(алдагдал)	2,252,773,351.08	1,690,766,558.47
5	Хүүгийн орлого	0.00	4,043,497.91
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,617,603,979.55	1,572,960,060.79
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	44,067,982.16	3,467,376.38
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-320,762,646.31	125,317,371.97
19	Орлогын татварын зардал	3,288,859.91	12,110,835.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-324,051,506.22	113,206,536.97
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-324,051,506.22	113,206,536.97

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,455,341,258.62	2,180,574,081.12
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,332,941,865.51	2,107,726,128.35
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	1,941,503.00	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	120,457,890.11	72,847,952.77
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,913,912,656.64	1,968,753,661.29
1.2.1	Ажиллагчдад төлсөн	966,143,153.85	951,102,289.05
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	304,290,420.52	270,629,630.45
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	26,814,870.00	23,087,778.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	40,588,417.81	50,201,157.60
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	53,877,076.00	11,482,731.50
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	416,802,720.03	404,347,518.94
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	6,752,384.00	2,045,620.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,098,643,614.43	255,856,935.75
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(458,571,398.02)	211,820,419.83
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	49,329,770.00	14,517,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	31,379,770.00	14,517,000.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	17,950,000.00	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(49,329,770.00)	(14,517,000.00)
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	142,760,000.00	100,000,000.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	142,760,000.00	100,000,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(142,760,000.00)	(100,000,000.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(650,661,168.02)	97,303,419.83
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,136,615,651.04	485,954,483.02
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	485,954,483.02	583,257,902.85

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	913,718,777.62	122,828,899.86	92,192,981.37	1,535,051,983.33	2,663,792,642.18
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
Залруулсан үлдэгдэл	913,718,777.62	122,828,899.86	92,192,981.37	1,535,051,983.33	2,663,792,642.18
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(324,051,506.22)	(324,051,506.22)

Өмчид гарсан өөрчлөлт					
Зарласан ногдол ашиг				(242,760,000.00)	(242,760,000.00)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		8,369,848.20			8,369,848.20
2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	913,718,777.62	131,198,748.06	92,192,981.37	968,240,477.11	2,105,350,984.16
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
Залруулсан үлдэгдэл	913,718,777.62	131,198,748.06	92,192,981.37	968,240,477.11	2,105,350,984.16
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				113,206,536.97	113,206,536.97
Зарласан ногдол ашиг					
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		2,449,280.50			2,449,280.50
2023 оны 12 сарын 31-р үлдэгдэл	913,718,777.62	133,648,028.56	92,192,981.37	1,081,447,014.08	2,221,006,801.63

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 он			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	2	3		4	5	6	7
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт						
	а/ Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	Биет	807,998.7	650,000.0	415,755.5	234,244.5	64.0
	Зураг төсөл боловсруулах ажил	Биет	969,076.6	892,610.5	914,970.1	(22,359.6)	102.5
	Норм, норматив боловсруулах	Биет	618,953.4	300,000.0	528,310.7	(228,310.7)	176.1
	/Бусад орлого /	Биет	543,320.5		7,903.2	(7,903.2)	
	б/ Үнийн дүнгээр	мян.төг	2,939,349.2	1,842,610.5	1,866,939.5	(24,329.0)	101.3
2	Нийт орлого	мян.төг	2,939,349.2	1,842,610.5	1,866,939.5	(24,329.0)	101.3
	Үүнээс: цэвэр борлуулалт	мян.төг	2,939,349.2	1,842,610.5	1,862,896.1	(20,285.6)	101.1
3	Нийт зардал	мян.төг	3,307,468.7	1,841,055.3	1,741,622.1	99,433.2	94.6
	Үүнээс: Ерөнхий ба удирдлагын зардал /Үйл ажиллагааны зардал /	мян.төг	2,480,715.5	1,509,955.3	1,476,563.9	33,391.4	97.8
	Мэргэжлийн ажил үйлчилгээний зардал	мян.төг	510,038.6	331,100.0	265,058.2	66,041.8	80.1
	Тусгай зөвшөөрөл эзэмших эрх олгох бэлтгэл ажил хангах зардал	мян.төг	316,714.6			-	
4	Татварын өмнөх ашиг	мян.төг	(368,119.2)	1,555.2	125,317.4	(123,762.2)	8,058.0
5	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	(324,051.5)	1,399.7	113,206.6	(111,806.9)	8,088.0
6	Төсвийн төлбөрт нийт дүн	мян.төг	534,456.8	313,217.1	563,592.7	(250,375.7)	179.9
	а/ Орлогын татвар	мян.төг	2,593.4		12,110.8	(12,110.8)	
	б/ НӨАТ	мян.төг	63,331.1	89,261.1	99,295.8	(10,034.8)	111.2
	в/ НДШ	мян.төг	145,390.4	123,829.2	136,847.9	(13,018.7)	110.5

	г/ Хүн амын орлогын албан татвар	мян.төг	115,656.4	81,176.9	100,075.7	(18,898.8)	123.3
	д/ ҮХХ Татвар	мян.төг	7,844.5	7,856.4	7,856.4	-	100.0
	ж/ Тээврийн хэр/татвар	мян.төг	1,292.1	2,602.8	2,602.8	-	100.0
	з/ бусад татвар	мян.төг	264,273.4	8,490.7	204,803.3	(196,312.6)	2,412.1
7	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	142,760.0	100,000.0	100,000.0	-	100.0
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	33.0	33.0	29.0	4.0	87.9
9	Нийт цалингийн сан	мян.төг	966,956.4	988,231.0	962,214.7	26,016.3	97.4
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	мян.төг	2,441.8	2,495.5	2,765.0	(269.5)	110.8
11	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	мян.төг	1,100.0	1.0	1.0	(0.0)	100.1
12	Хөрөнгө оруулалт	мян.төг	49,329.1	15,150.0	13,518.6	1,631.4	89.2
13	Авлага	мян.төг	929,691.2	262,800.0	758,741.1	(495,941.1)	288.7
14	Өглөг	мян.төг	530,868.6	244,000.0	235,319.6	8,680.4	96.4
	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	530,868.6	244,000.0	235,319.6	8,680.4	96.4
	Урт хугацаат өр төлбөр	мян.төг		-	-	-	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2.9 сая төгрөгийн 3 алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Худалдан авсан нийт 1.5 сая төгрөгийн сэлбэг, хангамжийн материал, бараа зэргийг бараа материалын дансаар дамжуулалгүй авлагын данснаас зардалд шууд бүртгэсэн	1	1,454.8			1	1,454.8	1	1,454.8				
Соёмбо тамга тэмдгийн үйлдвэрээр шинэчлүүлсэн ашиглагдаж байгаа тамга тэмдгийг хангамжийн материалд бүртгэхгүйгээр зардалд шууд тусгасан байна.	1	93.5			1	93.5	1	93.5				
Тайлант онд тооцооны дансаар дамжуулаагүй сургалтын зардал, цэвэр бохир усны болон зохицуулалтын үйлчилгээний хураамж зэрэг 1.4 сая төгрөгийг зардалд шууд тусгасан.	1	1,401.6			1	1,401.6	1	1,401.6				
Дүн	3	2,949.9			3	2,949.9	3	2,949.9				

Аудитаар нийт 18.9 сая төгрөгийн 5 зөрчил² илэрснээс, 0.5 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 18.4 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нийт 7.6 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулаагүй	1	7,611.2					1	7,611.2				
Өмнөх оны аудитаар 9.1 сая төгрөгийн актын төлбөрийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй бусад зардлаас шилжүүлсэн байна.	1	9,128.1					1	9,128.1				
Хүрээлэнгийн захирлын 2023 оны 05 сарын 23-ний өдрийн А/28 тушаалаар төрийн одон медаль болон тэргүүний ажилтнаар шагнагдсан ажилтан нарт 1.7 сая төгрөг олгосон	1	1,710.0					1	1,710.0				
Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 17 нэр төрлийн 155.4 сая төгрөгийн хөрөнгийн цаашид ашиглах хугацаа, шинэчлэн тогтоох үнийн саналыг боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлээгүй байна.	1	-					1	-				
Ахмад настнуудад хамтын гэрээний дагуу хүндэтгэл үзүүлэхэд 2,250.0 мянган төгрөг, Эрчим хүчний болон бусад тэргүүний ажилтан нарт 3,105.0 мянган төгрөгийн мөнгөн урамшил тус тус олгосноос суутгасан 10 хувийн татвар 0.5 сая төгрөгийг татварын байгууллагад шилжүүлээгүй.	1	535.5	1	535.5								
Дүн	5	18,984.8	1	535.5	-	-	4	18,449.3	-	-	-	-

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторовын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 367.9 сая төгрөгийн 1 зөрчил албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант хугацаанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 267.8 сая төгрөгийн 3 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 100.0 сая төгрөгийн 1 гүйлгээ нийт 367.8 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна.	1	367,875.5			1	367,875.5		
Дүн	1	367,875.5	-	-	1	367,875.5	-	-